ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДАА-2022/112/НА-СА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: peakomaudit@gmail.com<br>Дархан-Уул аймаг<br>2022 он | Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: **Ш.Мөнхбаяр**<br>Утас: **7037-3089**<br>Цахим хаяг: m**unkhbayarsh@audit.gov.mn**<br>Ахлах аудитор: **С.Батцэцэг**<br>Утас: **7037-3089**<br>Цахим хаяг: battsetsegs@**audit.gov.mn**<br>Аудитор: **Б.Жаргалсайхан**<br>Утас: **9986-2066**<br>Цахим хаяг: batjargalsaikhan@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 2
3. Аудитын тайлан ........ 12
   3.1 Ерөнхий зүйл ........ 12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 12
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 12
   3.4 Материаллаг байдал ........ 12
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 14
   3.8 Аудитын гол асуудал ........ 14
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 14
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 15
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 15
4. Аудитын илрүүлэлт ........ 15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 16

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

45059 Дархан-Уул аймаг,
Дархан сум, 14-р баг
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
E-mail: darkhanuul@audit.gov.mn

2022.02.25 № 155

танай ______________-ны № ______________-т

ДАРХАН УУЛ АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.БААСАНЖАРГАЛ ТАНАА

01 ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
ЗӨРЧИЛГҮЙ САНАЛ ДҮГНЭЛТ

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ /Ш.МӨНХБАЯР/

009020266

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **445,427,915.20** | **359,979,151.69** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **207,984,815.20** | **103,673,251.69** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **207,984,815.20** | **103,673,251.69** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **83,648,315.20** | **102,987,888.70** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 83,648,315.20 | 102,987,888.70 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 124,336,500.00 | 685,362.99 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **237,443,100.00** | **256,305,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **59,448,800.00** | **38,375,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 59,448,800.00 | 38,375,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **177,994,300.00** | **217,930,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 177,994,300.00 | 217,930,900.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **335,153,317.52** | **394,000,146.54** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **335,153,317.52** | **394,000,146.54** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **187,748,678.32** | **236,908,405.36** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **122,425,666.00** | **151,441,535.54** |
| 210101 | Үндсэн цалин | 72,018,266.00 | 92,283,656.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32,180,551.00 | 36,134,564.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,621,998.00 | 6,996,994.92 |
| 210104 | Урамшуулал | 14,604,851.00 | 16,026,320.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,558,142.00** | **18,579,864.98** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,784,205.00 | 13,250,570.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 985,125.00 | 1,476,534.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,004,347.00 | 1,181,227.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 326,754.00 | 242,867.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,457,711.00 | 2,428,666.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **2,062,216.00** | **4,389,340.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,298,682.00 | 2,901,418.00 |
| 210302 | Түлш, халаалт | 763,534.00 | 1,487,922.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,290,794.00** | **17,002,784.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,518,300.00 | 5,533,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,042,500.00 | 7,120,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,786,526.00 | 1,744,938.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 64,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 879,468.00 | 2,289,009.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | 166,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 148,737.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,548,200.00** | **2,985,500.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,905,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 553,200.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 1,995,000.00 | 80,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,979,000.00** | **36,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,979,000.00 | 36,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,999,058.00** | **7,029,558.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,582,500.00 | 5,937,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,500.00 | 280,500.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 257,100.00 | 200,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 56,958.00 | 116,058.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 174,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **21,885,602.32** | **35,443,822.84** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 850,000.00 | 1,409,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,450,000.00 | 1,300,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,585,602.32 | 32,734,022.84 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **147,404,639.20** | **157,091,741.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **660,000.00** | **2,468,657.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 660,000.00 | 2,468,657.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **146,744,639.20** | **142,772,049.18** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 87,295,839.20 | 104,397,049.18 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 59,448,800.00 | 38,375,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **11,851,035.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 11,851,035.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **110,274,597.68** | **(34,020,994.85)** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **81,232,127.40** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | - | 81,232,127.40 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **110,274,597.68** | **(115,253,122.25)** |

***Пийк-Ом Аудит ХХК***

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **234,101,027.46** | **-** | **591,684,409.14** | **825,785,436.60** |
| **2** | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **234,101,027.46** | **-** | **591,684,409.14** | **825,785,436.60** |
| **4** | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **-** | **-** | **-** | **-** |
| **5** | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **60,000,000.00** | **-** | **-** | **60,000,000.00** |
| **6** | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **-** | **-** | **-** | **-** |
| **7** | **Өмчид гарсан өөрчилөлт** | **-** | **-** | **-** | **-** |
| **8** | **Зарласан ногдол ашиг** | **-** | **-** | **-** | **-** |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | **-** | **-** | **110,274,597.68** | **110,274,597.68** |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **294,101,027.46** | **-** | **701,959,006.82** | **996,060,034.28** |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **294,101,027.46** | **-** | **701,959,006.82** | **996,060,034.28** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **294,101,027.46** | **-** | **701,959,006.82** | **996,060,034.28** |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| 17 | Өмчид гарсан өөрчилөлт | - | - | - | - |
| 18 | Зарласан ногдол ашиг | - | - | - | - |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | (115,253,122.25) | (115,253,122.25) |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **294,101,027.46** | **-** | **586,705,884.57** | **880,806,912.03** |

***Пийк-Ом Аудит ХХК***

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **332,942,450.20** | **359,293,788.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **83,648,315.20** | **102,987,888.70** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **83,648,315.20** | **102,987,888.70** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **83,648,315.20** | **102,987,888.70** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 83,648,315.20 | 102,987,888.70 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **249,294,135.00** | **256,305,900.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **71,299,835.00** | **38,375,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 71,299,835.00 | 38,375,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **177,994,300.00** | **217,930,900.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 177,994,300.00 | 217,930,900.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **329,219,250.20** | **349,973,988.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **329,219,250.20** | **349,973,988.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **169,963,576.00** | **204,733,282.52** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **122,425,666.00** | **151,441,535.54** |
| 210101 | Үндсэн цалин | 72,018,266.00 | 95,767,200.00 |
| 210102 | Нэмэгдэл | 32,180,551.00 | 32,651,020.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,621,998.00 | 6,996,994.92 |
| 210104 | Урамшуулал | 14,604,851.00 | 16,026,320.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **14,558,142.00** | **18,579,864.98** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,784,205.00 | 13,250,570.28 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 985,125.00 | 1,476,534.10 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,004,347.00 | 1,181,227.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 326,754.00 | 242,867.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,457,711.00 | 2,428,666.10 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **2,312,216.00** | **4,139,340.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,298,682.00 | 2,901,418.00 |
| 210302 | Түлш, халаалт | 1,013,534.00 | 1,237,922.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **11,994,794.00** | **15,676,284.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 3,507,300.00 | 5,998,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,742,500.00 | 6,377,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,786,526.00 | 1,744,938.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 64,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 894,468.00 | 1,555,446.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,245,700.00** | **3,714,900.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 689,900.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,249,700.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 1,996,000.00 | 3,025,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **2,979,000.00** | **36,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,979,000.00 | 36,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **9,998,058.00** | **6,895,358.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 8,581,500.00 | 5,792,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,500.00 | 280,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 114,058.00 | 116,058.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 184,800.00 |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.00 | 300,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **2,450,000.00** | **4,250,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,950,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,450,000.00 | 1,300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **159,255,674.20** | **145,240,706.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **660,000.00** | **2,468,657.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 660,000.00 | 2,468,657.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **158,595,674.20** | **142,772,049.18** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 87,295,839.20 | 104,397,049.18 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 71,299,835.00 | 38,375,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **3,723,200.00** | **9,319,800.00** |
| **IV** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **-** | **-** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **3,723,200.00** | **9,319,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,723,200.00** | **9,319,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **3,723,200.00** | **9,319,800.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,723,200.00 | 9,319,800.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **(3,723,200.00)** | **(9,319,800.00)** |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | **-** | **-** |
| **24** | **ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | **-** | **-** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **223,416,000.00** | **216,521,739.52** | **-6,894,260.48** | **96.91** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **223,416,000.00** | **216,521,739.52** | **-6,894,260.48** | **96.91** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **220,749,300.00** | **214,053,082.52** | **-6,696,217.48** | **96.97** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **151,472,300.00** | **151,441,535.54** | **-30,764.46** | **99.98** |
| 210101 | Үндсэн цалин | 94,255,500.00 | 95,767,200.00 | **1,511,700.00** | **101.60** |
| 210102 | Нэмэгдэл | 34,233,700.00 | 32,651,020.00 | **-1,582,680.00** | **95.38** |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,369,000.00 | 6,996,994.92 | **627,994.92** | **109.86** |
| 210104 | Урамшуулал | 16,614,100.00 | 16,026,320.62 | **-587,779.38** | **96.46** |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **20,448,700.00** | **18,579,864.98** | **-1,868,835.02** | **90.86** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,389,800.00 | 13,250,570.28 | **-1,139,229.72** | **92.08** |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,514,900.00 | 1,476,534.10 | **-38,365.90** | **97.47** |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,211,700.00 | 1,181,227.50 | **-30,472.50** | **97.49** |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 302,900.00 | 242,867.00 | **-60,033.00** | **80.18** |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,029,400.00 | 2,428,666.10 | **-600,733.90** | **80.17** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **5,882,200.00** | **4,139,340.00** | **-1,742,860.00** | **70.37** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,807,000.00 | 2,901,418.00 | **-905,582.00** | **76.21** |
| 210302 | Түлш, халаалт | 2,048,200.00 | 1,237,922.00 | **-810,278.00** | **60.44** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,000.00 | 0.00 | **-27,000.00** | **0.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **17,062,100.00** | **15,826,284.00** | **-1,235,816.00** | **92.76** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,007,300.00 | 5,998,900.00 | **-8,400.00** | **99.86** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,383,500.00 | 6,377,000.00 | **-6,500.00** | **99.90** |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,125,300.00 | 1,744,938.00 | **-1,380,362.00** | **55.83** |
| 210404 | Ном, хэвлэл | 150,000.00 | 150,000.00 | **0.00** | **100.00** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,396,000.00 | 1,555,446.00 | **159,446.00** | **111.42** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **12,725,000.00** | **12,634,700.00** | **-90,300.00** | **99.29** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,950,000.00 | 8,859,700.00 | **-90,300.00** | **98.99** |
| 210602 | Тавилга | 0.00 | 0.00 | **0.00** | **#DIV/0!** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 750,000.00 | 750,000.00 | **0.00** | **100.00** |
| 210604 | Урсгал засвар | 3,025,000.00 | 3,025,000.00 | **0.00** | **100.00** |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **1,286,500.00** | **36,000.00** | **-1,250,500.00** | **2.80** |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,286,500.00 | 36,000.00 | **-1,250,500.00** | **2.80** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **7,222,500.00** | **6,895,358.00** | **-327,142.00** | **95.47** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,800,000.00 | 5,792,000.00 | -8,000.00 | 99.86 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,500.00 | 280,500.00 | 0.00 | 100.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 200,000.00 | 200,000.00 | 0.00 | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 116,058.00 | -3,942.00 | 96.72 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 | 0.00 | 100.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 184,800.00 | -315,200.00 | 36.96 |
| 210807 | Газрын төлбөр | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,650,000.00** | **4,500,000.00** | **-150,000.00** | **96.77** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,200,000.00 | 3,200,000.00 | 0.00 | 100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,450,000.00 | 1,300,000.00 | -150,000.00 | 89.66 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,666,700.00** | **2,468,657.00** | **-198,043.00** | **92.57** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **2,666,700.00** | **2,468,657.00** | **-198,043.00** | **92.57** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,666,700.00 | 2,468,657.00 | -198,043.00 | 92.57 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **223,416,000.00** | **216,521,739.52** | **-6,894,260.48** | **96.91** |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **223,416,000.00** | **216,521,739.52** | **-6,894,260.48** | **96.91** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 223,416,000.00 | 216,521,739.52 | -6,894,260.48 | 96.91 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **23.00** | **23.00** | **0.00** | **100.00** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1.00** | **1.00** | **0.00** | **100.00** |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 | 0.00 | 100.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **11.00** | **11.00** | **0.00** | **100.00** |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 8.00 | 8.00 | 0.00 | 100.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 | 0.00 | 100.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **11.00** | **11.00** | **0.00** | **100.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 9.00 | 9.00 | 0.00 | 100.00 |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 0.00 | 0.00 | | |
| 650010 | Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 | 0.00 | 100.00 |

/төгрөгөөр/

***Пийк-Ом Аудит ХХК***

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **71,299,835.00** | **38,375,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **71,299,835.00** | **38,375,000.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | - | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | - |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | - |
| **2105** | **Нормативт зардал** | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | - |
| **2111** | **Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр** | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 71,299,835.00 | 38,375,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **71,299,835.00** | **38,375,000.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 71,299,835.00 | 38,375,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 71,299,835.00 | 38,375,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 71,299,835.00 | 38,375,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 71,299,835.00 | 38,375,000.00 |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

***Пийк-Ом Аудит ХХК***

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын орлого,зарлагыг холбогдох материалын дансаар бүрэн дамжуулж бүртгэх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг ахлах аудитор Б.Жаргалсайхан, аудитор Я.Батбаяр гүйцэтгэж, чанарын хяналтыг “Пийк-Ом Аудит” ХХК-ны чанарын хяналтын менежер Б. Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Пийк Ом Аудит ХХК-нд 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийн өмчийн газар нь орон нутгийн өмчийн талаарх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, удирдлагаар хангах, өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, Худалдан авах ажиллагааг ил тод нээлттэй, өрсөлдөх тэгш боломжтой хариуцлагатай, үр ашигтай зохион байгуулахад оршино гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Орон нутгийн өмчийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус төвийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын нэгж болон орон тоо байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 335,153.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 5,027.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн

материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,770.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 115,253.1 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 11,851.00 | - | (11,851.00) |
| Бараа материал | 3,017.50 | 3,576.40 | 558.90 |
| Үндсэн хөрөнгө | 981,191.50 | 877,230.50 | (103,961.00) |
| Нийт хөрөнгө | 996,060.00 | 880,806.90 | (115,253.10) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 996,060.00 | 880,806.90 | (115,253.10) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 996,060.00 | 880,806.90 | (115,253.10) |

Үндсэн хөрөнгө дансны хувьд тайлант онд төсвийн хөрөнгөөр 9,319.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, Бизнес инкубатор төвөөс 22,208.3 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, ном шилжүүлэн авч, Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 12 сарын 16-ны өдрийн 94 тоот тогтоолоор 91,336.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий 2 ширхэг Дэд станцын барилга, трансформаторыг “Дархан Сэлэнгийн түгээх сүлжээ” ХК-д шилжүүлж, 37,385.0 мянган төгрийн үндсэн хөрөнгө актлаж 6,767.6 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 877,230.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 880,806.9 мянган төгрөг болж 115,253.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 85,448.7 мянган төгрөгөөр буюу 19.2 хувиар буурсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 123,651.1 мянга, нэмэлт санхүүжилтийн орлогоо 21,073.0 мянган төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 58,846.8 мянган төгрөгөөр буюу 17.5 хувиар нэмэгдсэн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 29,015.8 мянга, хангамж, бараа материалын зардал 5,711.9 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 13,558.2 мянган төгрөгийн зардлууд байна. Энэ нь 2020 оны 01 дүгээр сарын 30 өдрийн 01-А/23 тоот Засаг даргын захирамжаар бүтэц орон тоо нэмсэн, үүнээс үүдэн ажлын байрны бэлтгэл ажил, бараа үйлчилгээ, хангамжийн материалын зардал өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 223,416.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 32,204.5 мянган төгрөгөөр бууруулж, 191,211.5 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 123,098.6 мянган төгрөгөөр төсөвлөсөн нь өнгөрсөн оны батлагдсан төсвөөс 7,214.0 мянган төгрөгөөр бага, тайлант оны батлагдсан төсвөөс 28,373.7 мянган төгрөгөөр өндөр байна.

Төсвийн тодотголоор 223,416.0 мянган төгрөг болгож 32,204.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бүтэц орон тоонд өөрчилөлт орсонтой холбоотой юм.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 223,416.0 мянган төгрөгийн төсөв батлаcнаас орон нутгийн төсвөөс 223,416.0 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 217,930.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 216,521.7 мянган төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсвөөс 1,409.2 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 216,521.7 мянган төгрөг буюу 96.91 хувьтай байна. 2021 онд бараа ажил үйлчилгээний зардал 6,696.0 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 38,375.0 мянган төгрөг орж ирсэнийг Да-бусад нэр заагдаагүй орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Төсвийн шууд захирагч үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал, санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**3.8 Аудитын гол асуудал**

Дархан -Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохиох 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар шилэн дансны цахим хуудсанд оруулаагүй 15 мэдээлэл, элэгдэлээрээ анхны өртөгөө нөхсөн 30 нэр төрлийн үндсэн хөрөнгийн ашиглалтын түвшинг тогтоож, дахин үнэлэх, актлах арга хэмжээ аваагүй байсан. Биелэлтийг 2021 оны 11 сарын 01-ны өдрийн 548-1 тоот албан бичигээр ирүүлсэн ба тайлагналын дараах үе шатанд дахин хянахад хэрэгжилт 100 хувьтай байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,838.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Залруулсан алдаа байхгүй.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Бараа материалын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Аудитын явцад бараа материалын үлдэгдэл, орлого, зарлагын гүйлгээг түүвэрлэн тулгахад бараа материалын ангилал, дансны нэгдсэн жагсаат болон УСНББОУС 12-ыг мөрдөөгүйн улмаас санхүүгийн тайлангийн 1,838.7 мянган төгрөгийн бараа материалыг ангилал буруу бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт “нягтлан бодох бүртгэлийн дансы заавар”, УСНББОУС 12 "Бараа материал" стандартын 37 дугаар зүйлд зааснаар бараа материалыг ... хуваарилах үед тэдгээр бараа материалын дансны үнийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрөх ёстой гэж заасантай нийцэхгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Худалдан авсан бараа материалын орлого, зарлагыг холбогдох материалын дансаар бүрэн дамжуулан бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мян төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газар | 1 | 1,838.7 | - | - | - | - | 1 | 0 | 1 | 1,838.7 |
| | Дүн | 1 | 1,838.7 | - | 0 | 0 | 0 | 1 | 0 | 1 | 1,838.7 |

ПИЙК-ОМ АУДИТ ХХК

2022.02.25